

“МАХ ИМПЭКС” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 15 өдөр

№2

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1 болон 64.2 дахь хэсэг, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.3 дахь хэсэг, Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын хоёрдугаар зүйл мөн журмын гуравдугаар зүйл болон дөрөвдүгээр зүйлд заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 сарын 26-ны өдөр 14:00 цагт өөрийн байрнаас цахим хэлбэрээр шууд дамжуулан хуралдуулсугай.
2. Дээрх хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
 - ✓ 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - ✓ Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 - ✓ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг батлах;
 - ✓ Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг хэлэлцэн батлах;
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 сарын 06-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай мэдэгдлийг “Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж”-д мэдэгдэх өдрийг 2024 оны 03 сарын 18-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2024 оны 03 сарын 20-ны өдөр болон 2024 оны 04 сарын 04-ний өдрүүдэд байхаар тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай зарыг 2024 оны 03 сарын 20-ны өдөр Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2024.03.20-ны өдөр болон 2024.04.04-ны өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Дараах бичиг баримтуудыг компани дээр 2024.03.20-ны дотор бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах, 2024.03.25-ны дотор брокер, дилерийн компанид хүргүүлэх ажлыг зохион байгуулсугай. Үүнд:
 - 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр;
 - 6.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах талаар нийтэд мэдээлэх зарын загвар;
 - 6.3. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын хуулбар;
 - 6.4. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны бизнес төлөвлөгөө;

- 6.5.Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт;
- 6.6.Хувьцаа эзэмшигчдийн санал хураах хуудас;
- 6.7.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч намтар, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв;
7. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2024.04.26-ны өдрийн 12:00 цагаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарын загварыг энэхүү тогтоолын хавсралт №1-ээр баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарын санал хураах хуудасны загварыг энэхүү тогтоолын хавсралт №2-оор баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг энэхүү тогтоолын хавсралт №3-аар баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Л.Янжин, нарийн бичгийн даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга И.Өлзийбаяр, тэргүүлэгчдээр хувьцаа эзэмшигч Д.Самдан, Ж.Сүхболд нарыг сонгосугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.
- | | | |
|------------------|-------------|------------------|
| Комиссын дарга: | И.Галтхүү | /Нягтлан бодогч/ |
| Комиссын гишүүд: | Ч.Мөнх-очир | /Нягтлан бодогч/ |
| | Д.Бурмаа | /Нягтлан бодогч/ |
| | Б.Хонгорзул | /Нягтлан бодогч/ |
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.
- | | | |
|-----------------------|--------------|------------------------------|
| Комиссын дарга: | М.Жаргалмаа | /Хуулийн зөвлөх/ |
| Нарийн бичгийн дарга: | И.Өлзийбаяр | /ТУЗ нарийн бичгийн дарга/ |
| Гишүүд: | Н.Маралсүрэн | /Ерөнхий инженер/ |
| | Н.Одгэрэл | /Үйлдвэрийн дарга/ |
| | Х.Ууганбаяр | /Хуулийн зөвлөх/ |
| | Б.Өнөрмаа | /Хүний нөөцийн албаны дарга/ |
| | Ц.Нараа | /Маркетингийн албаны дарга/ |
14. Компанийн хувьцаа эзэмшигчдэд хурлын материал, танилцуулгыг тараах, хурлын бэлтгэл ажлыг сайтар зохион байгуулж ажиллахыг Хурал зохион байгуулах комиссын дарга /М.Жаргалмаа/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ЦЭНГҮҮН